

Дотоод Явдлын Яамны Засан хүмүүжүүлэх үйлдвэрийн лагериуд ба хорих ангиудыг удирдах газрын даргаар 1945-1948 онд ажиллаж байсан Тасрангийн Бавуудорж: Олзлогдсон япон цэргүүдийн хумсны толион дээр ханзаар бичсэн нэр хаягийн тухай өгүүлсэн нь<sup>1</sup>

Түүхийн шинжлэх ухааны доктор О.Батсайхан,  
Монгол Улсын ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн

Энэ жил Монгол Улс Япон Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ой тохиож буй билээ. Эл ойн хүрээнд Дэлхийн хоёрдугаар дайны дараа Зөвлөлт Холбоот Улсад олзлогдсон япон цэргүүдээс тодорхой тооны цэргүүдийг Монголд өгч, ажиллуулж байсан тухай бид мэдэх юм. Харин энэ үед буюу 1945 оны 10 дугаар сараас 1948 оны 2 дугаар сар хүртэл Дотоод явдлын яамны Засан хүмүүжүүлэх үйлдвэрийн лагериуд ба Хорих ангиудыг удирдах газрын даргаар, мөн тус яамны Намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Тасрангийн Бавуудорж гуай 1989-90 оны үед дурдатгалаа өөрийн гараар бичиж, над өгсөн юм. Тэрбээр дурдатгалдаа 1930-аад оны Монголын түүхийн ээдрээ бүхий зарим асуудлаар, тухайлбал 1932 оны "лам нарын бослогын" талаар, Өрлөг Жанжин Дэмидийн тухай, Маршаал Чойбалсангийн өөрийгээ илчлэх тушаалын талаар онц сонирхолтой зүйлс бичиж тэмдэглэсэн байдаг. Үүний зэрэгцээ Олзлогдсон япон цэргүүд нутаг буцах болоход Японы олзлогдсон цэргийн Ерөөгийн лагерийн дарга хошууч Иший "тэнд үхсэн цэргүүдийнхээ эрхий хурууг огтлон аваад овог, нэр, нас, нутгийг тэмдэглэн бичиж" авч явсан тухай сонирхолтой зүйлс тэмдэглэснийг энд өгүүлэх болно. Харин 1945 оны 12 дугаар сарын 12-нд Сайд нарын Зөвлөлийн дэргэд байгуулагдсан Олзлогдсон цэргийн хэрэг эрхлэх ерөнхий газрын даргаар нь Бадамжавын Сосорбарам ажиллаж байсан байдаг билээ. 1947 оны 11 дүгээр сарын 4-нд Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Олзлогдсон цэргийн хэрэг эрхлэх газрыг өргөтгөн БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Барилгын хэргийг эрхлэх ерөнхий газар болгон байгуулсан байдаг. Энэхүү дурдатгалын эзэн Т.Бавуудорж бол 1948 оны 2 дугаар сараас 1956 оны 9 дүгээр сар хүртэл БНМАУ-ын Аж Үйлдвэрийн яамны сайдаар ажиллаж байсан хүн юм. Тэрбээр Засагт хан аймгийн Эрдэнэ дүүрэгч вангийн хошуу буюу одоогийн Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын харьяат нэгэн билээ.

К"Олзлогдсон япончууд Монголд судалгааны өгүүлэл Токиогийн Япон Монголын Найрамдал сэтгүүлийн 2005 оны 3 дугаар сарын 110 дугаарт япон хэлээр хэвлэгдэв. 56-72 дахь тал ("Nihon to Mongoru" Number 110, March of 2005 (Japanese) )